



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/27

Ханх сум

Мал, амьтны сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.3.4, Захиргааны ерөнхий хуулийн 40.1, 40.2, 40.3, 40.4, аймгийн Засаг даргын 2024 оны 03-р сарын 25-ны өдрийн А/122 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малын гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилт, хаваржилтын хүндрэл болон зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах, малын бэлчээр, бууц, хашаа байр, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 04-р сарын 23-ны өдрөөс эхлэн 05-р сарын 15-ны өдрийн дотор сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Ариутгал, халдваргүйтгэл, зэг зэм устгалын ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж төлөвлөгөө, удирдамж гарган биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч /Э.Алтангэрэл/-д, Хамтран ажиллах гэрээний дагуу сэг зэм цуглуулж, тогтоосон координатын цэгт тээвэрлэн хүргэж устгахыг Туртын Баян-хайрхан уул ХХК-ний захирал Б.Пүрэв-Очирт, тухайн багийн нутаг дэвсгэрийн маршрут зураглалыг гаргаж иргэдээс мэдээ мэдээлэл авах, захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хамтран ажиллахыг Тураг 1-р багийн Засаг дарга Ш.Отгонжаргал, Хороо 2-р багийн Засаг дарга Б.Анхбаяр, Турт 3-р багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Э.Мөнхжаргал, Баясгалант 4-р багийн Засаг дарга Б.Бямбабаяр нарт үүрэг болгосугай.

3. Ариутгал, халдваргүйтгэл, зэг зэм устгалын ажилд шаардагдах шатах тослох материал, хамгаалах хувцас хэрэгсэл болон бусад зардлыг хуулийн дагуу тооцож шийдвэрлэхийг Засаг даргын тамгын газрын дарга /Б.Баасансүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Баттүвшин/-д даалгасугай.

ДАРГА

Л.ДАВААБАЯР



My doc-2024 Zahiramj

8707000096